



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН  
2024 ОНЫ НЭГДҮГЭЭР  
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

# АГУУЛГА

<b>НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
<b>ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	10
<b>ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	11
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	11
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	12
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	13
<b>ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	15
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	15
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	16
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	17
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	18
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	18
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	18
<b>ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА</b> .....	19
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	19
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	19
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	20
<b>ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> .....	21
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	21

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024.04.30


Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 184 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 ХЗХ буюу 3.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 48.4 хувь буюу 89 ХЗХ орон нутагт, 51.6 хувь буюу 95 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/



ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон,

хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээх, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 5 ХЗХ-ны 13 сонгуульт гишүүн, 1 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2020	2021	2022	2023	2024.I
ХЗХ-дын тоо	249	209	196	191	184
Шинээр олгосон	14	-	7	3	-
Хүчингүй болгосон	26	40	20	8	7
Түдгэлзүүлсэн	23	12	13	12	1
Сэргээсэн	6	1	3	1	1
ТЗ-ийн хугацаа сунгасан	49	85	62	-*	-*

\*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 184 ХЗХ, 61 салбар, 651 ажилтан, 73,293 гишүүн /73,014 иргэн, 279 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод 95 ХЗХ Багахангай дүүргээс бусад дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 ХЗХ буюу 5.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 89 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Сэлэнгэ аймагт тусгай зөвшөөрөлтэй ХЗХ байхгүй боловч “Гялс төгрөг” ХЗХ-ны 6 салбар байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


## 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,331 буюу 4.8 хувиар өсөж 73,293-т хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.4 хувь буюу 279 нь хуулийн этгээд, 53.6 хувь буюу 39,272 нь эмэгтэй гишүүд байна.



Нийт гишүүдийн 54.7 хувь буюу 40,103 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 45.3 хувь буюу 33,190 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч 2020 оны 1 дүгээр улирлаас 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсөж байсан бол 2023 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 6.7 хувь буурч, тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Нийт 184 ХЗХ-ны 29.9 хувь буюу 55 ХЗХ 20-100 гишүүнтэй, 52.7 хувь буюу 97 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.3 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 7.1 хувь буюу 13 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	55	3,056	4.2%
101-500 гишүүнтэй	97	21,178	28.9%
501-1,000 гишүүнтэй	19	13,164	18.0%
1,001-ээс дээш гишүүнтэй	13	35,895	49.0%
<b>Нийт</b>	<b>184</b>	<b>73,293</b>	<b>100.0%</b>

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 13 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 49.0 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



## 1.4 Бодлого, зохицуулалтын орчин

### Хамтын ажиллагаа

- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 2023 оны хэрэгжилтийг дүгнэж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан.

### Хууль, эрх зүйн орчин

- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар баталсан.

Журамд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих талаар Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн дэлгэрэнгүй тусгаж, эрсдэлийн санг ангилах бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулж, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинэчилсэн.


Журам шинэчлэн баталсантай холбоотойгоор Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 50/144 тоот тушаалаар Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны 232/216 дугаар “Заавар, дансны жагсаалт, аргачлал болон маягт батлах тухай” тушаалыг хүчингүй болгосон.

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 148 дугаар тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны дотоод хяналтын шалгах хуудас”-ыг баталсан. Хяналтын зөвлөл шалгах хуудсыг удирдлага болгон өөрийн хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийг тогтмол үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллах боломжтой болсон.



Нийт гишүүдийн 44.4 хувь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 67.5 хувь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>184</b>	<b>100.0%</b>	<b>95</b>	<b>51.6%</b>	<b>89</b>	<b>48.4%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>220,265,413.89</b>	<b>100.0%</b>	<b>163,230,392.59</b>	<b>74.1%</b>	<b>57,035,021.30</b>	<b>25.9%</b>
<b>Нийт зээлдэгчийн тоо</b>	<b>31,619</b>	<b>100.0%</b>	<b>14,870</b>	<b>47.0%</b>	<b>16,749</b>	<b>53.0%</b>
Иргэн	31,520	99.7%	14,786	99.4%	16,734	99.9%
Эмэгтэй	16,854	53.3%	7,886	53.0%	8,968	53.5%
Хуулийн этгээд	99	0.3%	84	0.6%	15	0.1%
<b>Зээлдэгчдийн насжилт</b>	<b>31,520</b>	<b>100.0%</b>	<b>14,786</b>	<b>46.9%</b>	<b>16,734</b>	<b>53.1%</b>
18-35 насны	8,296	26.3%	4,299	29.1%	3,997	23.9%
36-45 насны	10,188	32.3%	5,107	34.5%	5,081	30.4%
46-55 насны	8,859	28.1%	4,084	27.6%	4,775	28.5%
55-аас дээш	4,177	13.3%	1,296	8.8%	2,881	17.2%
<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	<b>31,520</b>	<b>100.0%</b>	<b>14,786</b>	<b>46.9%</b>	<b>16,734</b>	<b>53.1%</b>
Дээд	11,623	36.9%	6,479	43.8%	5,144	30.7%
Тусгай дунд	6,303	20.0%	3,563	24.1%	2,740	16.4%
Бүрэн дунд	7,424	23.6%	2,350	15.9%	5,074	30.3%
Дунд	4,715	15.0%	2,303	15.6%	2,412	14.4%
Бага	1,455	4.6%	91	0.6%	1,364	8.2%

Тайлант улиралд ХЗХ-д 31,619 зээлдэгчийн 220,265,413.89 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 47.0 хувь буюу 14,870 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 74.1 хувь буюу 163,230,392.59 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 53.0 хувь буюу 16,749 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 25.9 хувь буюу

57,035,021.30 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 31,520 нь хувь хүн (53.3 хувь буюу 16,854 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 99 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 6,966.24 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 10,977.16 мянган төгрөг, орон нутагт 3,405.28 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>184</b>	<b>100.0%</b>	<b>95</b>	<b>51.6%</b>	<b>89</b>	<b>48.4%</b>
<b>Нийт хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>219,943,391.37</b>	<b>100.0%</b>	<b>173,144,387.91</b>	<b>78.7%</b>	<b>46,799,003.45</b>	<b>21.3%</b>
<b>Нийт хадгаламж эзэмшигчийн тоо</b>	<b>45,624</b>	<b>100.0%</b>	<b>23,953</b>	<b>52.5%</b>	<b>21,671</b>	<b>47.5%</b>
Эмэгтэй	25,740	56.4%	12,872	53.7%	12,868	59.4%
<b>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>4,465,609.14</b>	<b>2.0%</b>	<b>3,796,686.15</b>	<b>2.2%</b>	<b>668,922.99</b>	<b>1.4%</b>

Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	5,047	11.1%	3,865	16.1%	1,182	5.5%
Иргэн	5,029	11.0%	3,847	16.1%	1,182	5.5%
Хуулийн этгээд	18	0.0%	18	0.1%	-	0.0%
<b>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>215,477,782.22</b>	<b>98.0%</b>	<b>169,347,701.76</b>	<b>97.8%</b>	<b>46,130,080.46</b>	<b>98.6%</b>
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	40,577	88.9%	20,088	83.9%	20,489	94.5%
Иргэн	40,527	88.8%	20,073	83.8%	20,454	94.4%
Хуулийн этгээд	50	0.1%	15	0.1%	35	0.2%
<b>Хадгаламж эзэмшигчдийн нажилт</b>	<b>45,556</b>	<b>100.0%</b>	<b>23,920</b>	<b>100.0%</b>	<b>21,636</b>	<b>100.0%</b>
18-35 насны	17,127	37.6%	10,941	45.7%	6,186	28.6%
36-45 насны	11,544	25.3%	5,500	23.0%	6,044	27.9%
46-55 насны	9,339	20.5%	4,131	17.3%	5,208	24.1%
56-аас дээш	7,546	16.6%	3,348	14.0%	4,198	19.4%
<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	<b>45,556</b>	<b>100.0%</b>	<b>23,920</b>	<b>100.0%</b>	<b>21,636</b>	<b>100.0%</b>
Дээд	20,420	44.8%	13,788	57.6%	6,632	30.7%
Тусгай дунд	6,985	15.3%	3,963	16.6%	3,022	14.0%
Бүрэн дунд	9,729	21.4%	3,872	16.2%	5,857	27.1%
Дунд	5,067	11.1%	979	4.1%	4,088	18.9%
Бага	3,355	7.4%	1,318	5.5%	2,037	9.4%

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 45,624 хадгаламж эзэмшигчийн 219,943,391.37 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.5 хувь буюу 23,953 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 78.7 хувь буюу 173,144,387.91 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.5 хувь буюу 21,671 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 21.3 хувь буюу 46,799,003.45 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 316,175,331.15 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 хувь буюу 41,627,395.89 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 3.7 хувь буюу 7,782,474.52 мянган төгрөгөөр,

Нийт хадгаламж эзэмшигчийн 2.0 хувийг хугацаагүй, 98.0 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.9 хувь буюу 45,624 нь хувь хүн (56.5 хувь буюу 25,740 нь эмэгтэй), 0.1 хувь буюу 68 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 4,820.78 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,228.51 мянган төгрөг, орон нутагт 2,159.52 мянган төгрөг байна.

нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 14.9 хувь буюу 28,493,239.06 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 10.9 хувь буюу 1,717,839.29 мянган төгрөгөөр, нийт зарлага 10.7 хувь буюу 1,509,728.99 мянган төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 1,860,594.59 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 58.7 хувь буюу 108 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны I улирал	2024 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>274,547,935.26</b>	<b>316,175,331.15</b>	<b>41,627,395.89</b>	<b>15.2%</b>
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.6%		
<b>Нийт зээл</b>	<b>212,482,939.37</b>	<b>220,265,413.89</b>	<b>7,782,474.52</b>	<b>3.7%</b>
Банкны салбарт эзлэх хувь	0.9%	0.7%		
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>7,516,805.43</b>	<b>6,905,829.02</b>	<b>-610,976.41</b>	<b>-8.1%</b>
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.5%	3.1%	-0.4%	-11.4%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.3%	0.0%	-0.6%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>191,450,152.31</b>	<b>219,943,391.37</b>	<b>28,493,239.06</b>	<b>14.9%</b>
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.0%		
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>26,570,075.81</b>	<b>28,327,858.14</b>	<b>1,757,782.34</b>	<b>6.6%</b>
<b>Нийт хоршоологчдын өмч Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	<b>32,601,894.64</b>	<b>42,744,977.06</b>	<b>10,143,082.42</b>	<b>31.1%</b>
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	8,128,728.84	4,231,964.49	-3,896,764.35	-47.9%
Нийт орлого	15,748,355.78	17,466,195.07	1,717,839.29	10.9%
Нийт зарлага	14,095,871.48	15,605,600.48	1,509,728.99	10.7%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>1,652,484.29</b>	<b>1,860,594.59</b>	<b>208,110.30</b>	<b>12.6%</b>

### 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 95 ХЗХ-ны нийт хөрөнгө 246,158,382.62 мянган төгрөг нь зах зээлийн 77.9 хувь, нийт зээл 163,230,392.59 мянган төгрөг нь зах зээлийн 74.1 хувь, нийт хадгаламж 173,144,387.91 мянган төгрөг нь зах зээлийн 78.7 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувь буюу 528,138.32 мянган төгрөгөөр буурч 6,010,994.12 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.7 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 52.6 хувь буюу 4,269,963.02 мянган

төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 12.6 хувь буюу 1,456,479.02 мянган төгрөгөөр, нийт зарлага 10.0 хувь буюу 1,077,882.04 мянган төгрөгөөр тус тус өсөж, цэвэр орлого 1,223,963.87 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 53.0 хувь буюу 57 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны I улирал	2024 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>214,787,684.19</b>	<b>246,158,382.62</b>	<b>31,370,698.43</b>	<b>14.6%</b>
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	78.2%	77.9%	-0.4%	-0.5%
<b>Нийт зээл</b>	<b>162,546,862.15</b>	<b>163,230,392.59</b>	<b>683,530.45</b>	<b>0.4%</b>
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	76.5%	74.1%	-2.4%	-3.1%
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>6,539,132.44</b>	<b>6,010,994.12</b>	<b>-528,138.32</b>	<b>-8.1%</b>
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	87.0%	87.0%	0.0%	0.1%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.0%	3.7%	-0.3%	-8.5%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>151,698,034.24</b>	<b>173,144,387.91</b>	<b>21,446,353.68</b>	<b>14.1%</b>

ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	79.2%	78.7%	-0.5%	-0.6%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>19,496,643.57</b>	<b>20,519,899.29</b>	<b>1,023,255.72</b>	<b>5.2%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	73.4%	72.4%	-0.9%	-1.3%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>23,584,616.62</b>	<b>32,204,646.74</b>	<b>8,620,030.12</b>	<b>36.5%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	72.3%	75.3%	3.0%	4.1%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	<b>8,118,728.84</b>	<b>3,848,765.23</b>	<b>-4,269,963.61</b>	<b>-52.6%</b>
Нийт орлого	11,574,122.09	13,030,601.10	1,456,479.02	12.6%
Нийт зарлага	10,728,755.19	11,806,637.23	1,077,882.04	10.0%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>845,366.90</b>	<b>1,223,963.87</b>	<b>378,596.97</b>	<b>44.8%</b>

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 89 ХЗХ-ны нийт хөрөнгө 70,016,948.52 мянган төгрөг нь зах зээлийн 22.1 хувь, нийт зээлийн үлдэгдэл 57,035,021.30 мянган төгрөг нь зах зээлийн 25.9 хувь, нийт хадгаламж 46,799,003.45 мянган төгрөг нь зах зээлийн 21.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 6.3 хувь буюу 261,360.27 мянган төгрөгөөр, нийт зарлага 12.8 хувь буюу 431,846.95 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн боловч нийт

цэвэр орлого 21.1 хувь буюу 170,486.68 мянган төгрөгөөр буурч 636,630.71 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 51.6 хувь буюу 47 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны I улирал	2024 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>59,760,251.06</b>	<b>70,016,948.52</b>	<b>10,256,697.46</b>	<b>17.2%</b>
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	21.8%	22.1%	0.4%	1.7%
<b>Нийт зээл</b>	<b>49,936,077.23</b>	<b>57,035,021.30</b>	<b>7,098,944.08</b>	<b>14.2%</b>
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	23.5%	25.9%	2.4%	10.2%
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>977,672.99</b>	<b>894,834.90</b>	<b>-82,838.09</b>	<b>-8.5%</b>
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	13.0%	13.0%	0.0%	-0.4%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.6%	0.5%	-0.1%	-8.9%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>39,752,118.07</b>	<b>46,799,003.45</b>	<b>7,046,885.38</b>	<b>17.7%</b>
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	20.8%	21.3%	0.5%	2.5%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>7,073,432.24</b>	<b>7,807,958.85</b>	<b>734,526.61</b>	<b>10.4%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	26.6%	27.6%	0.9%	3.5%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>9,017,278.02</b>	<b>10,540,330.32</b>	<b>1,523,052.30</b>	<b>16.9%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	27.7%	24.7%	-3.0%	-10.8%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	<b>10,000.00</b>	<b>383,199.26</b>	<b>373,199.26</b>	<b>3732.0%</b>
Нийт орлого	4,174,233.69	4,435,593.96	261,360.27	6.3%
Нийт зарлага	3,367,116.30	3,798,963.25	431,846.95	12.8%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>807,117.39</b>	<b>636,630.71</b>	<b>-170,486.68</b>	<b>-21.1%</b>

## ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


### 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2023 оны I улирал		2024 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>270,451,058.55</b>	<b>98.5%</b>	<b>312,000,095.31</b>	<b>98.7%</b>	<b>41,549,036.76</b>	<b>15.4%</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>42,491,357.22</b>	<b>15.5%</b>	<b>71,691,535.26</b>	<b>22.7%</b>	<b>29,200,178.04</b>	<b>68.7%</b>
Бэлэн мөнгө	5,031,679.67	1.8%	3,488,466.54	1.1%	-1,543,213.12	-30.7%
Банкинд байршуулсан харилцах	8,220,527.08	3.0%	11,890,959.70	3.8%	3,670,432.62	44.6%
Банкинд байршуулсан хадгаламж	29,239,150.47	10.6%	56,312,109.01	17.8%	27,072,958.54	92.6%
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	<b>700,000.00</b>	<b>0.3%</b>	<b>820,000.00</b>	<b>0.3%</b>	<b>120,000.00</b>	<b>17.1%</b>
Арилжааны үнэт цаас	700,000.00	0.3%	820,000.00	0.3%	120,000.00	17.1%
<b>Зээл /цэврээр/</b>	<b>207,853,296.94</b>	<b>75.7%</b>	<b>214,829,871.37</b>	<b>67.9%</b>	<b>6,976,574.44</b>	<b>3.4%</b>
Нийт зээл	212,482,939.37	77.4%	220,265,413.89	69.7%	7,782,474.52	3.7%
Хэвийн зээл	196,564,430.65	71.6%	205,061,934.19	64.9%	8,497,503.54	4.3%
Хугацаа хэтэрсэн зээл	8,401,703.29	3.1%	8,297,650.68	2.6%	-104,052.61	-1.2%
Чанаргүй зээл	7,516,805.43	2.7%	6,905,829.02	2.2%	-610,976.41	-8.1%
(Зээлийн эрсдэлийн сан )	4,629,642.43	1.7%	5,435,542.52	1.7%	805,900.08	17.4%
<b>Авлага</b>	<b>17,300,657.90</b>	<b>6.3%</b>	<b>19,627,900.43</b>	<b>6.2%</b>	<b>2,327,242.53</b>	<b>13.5%</b>
Байгууллага, хүмүүсээс авах авлага	7,947,599.46	2.9%	7,577,478.76	2.4%	-370,120.70	-4.7%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	9,353,058.44	3.4%	12,050,421.67	3.8%	2,697,363.23	28.8%
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	<b>1,133,524.41</b>	<b>0.4%</b>	<b>4,100,859.56</b>	<b>1.3%</b>	<b>2,967,335.14</b>	<b>261.8%</b>
<b>Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/</b>	<b>972,222.08</b>	<b>0.4%</b>	<b>929,928.69</b>	<b>0.3%</b>	<b>-42,293.39</b>	<b>-4.4%</b>
Өмчлөх бусад хөрөнгө	1,010,535.40	0.4%	972,518.88	0.3%	-38,016.52	-3.8%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	38,313.32	0.0%	42,590.19	0.0%	4,276.87	11.2%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,096,876.71</b>	<b>1.5%</b>	<b>4,175,235.84</b>	<b>1.3%</b>	<b>78,359.13</b>	<b>1.9%</b>
<b>Үндсэн хөрөнгө /цэвр/</b>	<b>3,877,771.50</b>	<b>1.4%</b>	<b>3,995,636.12</b>	<b>1.3%</b>	<b>117,864.62</b>	<b>3.0%</b>
Үндсэн хөрөнгө	6,307,367.08	2.3%	6,586,673.27	2.1%	279,306.18	4.4%
(Хуримтлагдсан элэгдэл)	2,429,595.58	0.9%	2,591,037.15	0.8%	161,441.56	6.6%
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>203,602.52</b>	<b>0.1%</b>	<b>164,097.03</b>	<b>0.1%</b>	<b>-39,505.49</b>	<b>-19.4%</b>
Биет бус хөрөнгө	324,077.58	0.1%	326,942.57	0.1%	2,864.98	0.9%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	120,475.06	0.0%	162,845.54	0.1%	42,370.47	35.2%
<b>Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө</b>	<b>15,502.69</b>	<b>0.0%</b>	<b>15,502.69</b>	<b>0.0%</b>	<b>0.0</b>	<b>0.0%</b>
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,502.69	0.0%	15,502.69	0.0%	0.0	0.0%
<b>Хөрөнгийн дүн</b>	<b>274,547,935.26</b>	<b>100.0%</b>	<b>316,175,331.15</b>	<b>100.0%</b>	<b>41,627,395.89</b>	<b>15.2%</b>

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 316,175,331.15 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 хувь буюу 41,627,395.89 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.7 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 22.7 хувийг, цэвр зээл 67.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)




Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7 хувь буюу 7,782,474.52 мянган төгрөгөөр өсөж 220,265,413.89 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,435,542.52 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 214,829,871.37 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувь буюу 104,052.61 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2020 оны 1 дүгээр улирлаас

тайлант улирал хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо тогтмол буурсан ч хөрөнгийн хэмжээ дунджаар 7.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 6: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/




### 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 182,767,646.01 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 57.8 хувийг, гишүүдийн тоо 19,784 байгаа нь нийт гишүүдийн 27.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	182,767,646.01	57.8%	19,784	27.0%
2	1,000,000.0 -10,000,000.0	29	97,212,236.97	30.7%	25,592	34.9%
3	500,000.0-1,000,000.0	22	16,143,653.43	5.1%	9,932	13.6%
4	100,000.0-500,000.0	73	16,730,847.75	5.3%	13,370	18.2%
5	50,000.0-100,000.0	37	2,773,128.25	0.9%	3,358	4.6%
6	10,000.0-50,000.0	17	538,580.69	0.2%	1,187	1.6%
7	10,000.0 хүртэл	2	9,238.05	0.00%	70	0.1%
<b>Нийт дүн</b>		<b>184</b>	<b>316,175,331.15</b>	<b>100.0%</b>	<b>73,293</b>	<b>100.0%</b>



### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 220,265,413.89 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 69.7 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 214,829,871.37 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 67.9 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.4 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.7 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 29 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 85.5 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	29	188,319,934.14	85.5%
2	500,000.0-1,000,000.0	17	12,136,926.77	5.5%
3	100,000.0-500,000.0	69	16,148,148.14	7.3%
4	50,000.0-100,000.0	37	2,770,486.69	1.3%
5	10,000.0-50,000.0	27	870,816.64	0.4%
6	10,000.0 хүртэл	4	19,101.52	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	1	-	-
<b>Нийт дүн</b>		<b>184</b>	<b>220,265,413.89</b>	<b>100%</b>

### 3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Нийт</b>	<b>31,619</b>	<b>100.0%</b>	<b>220,265,413.89</b>	<b>100.0%</b>
Хэвийн	29,424	93.1%	205,061,934.19	93.1%
Хугацаа хэтэрсэн	881	2.8%	8,297,650.68	3.8%
Чанаргүй	1,314	4.2%	6,905,829.02	3.1%
<i>Хэвийн бус</i>	365	27.8%	1,744,986.85	25.3%
<i>Эргэлзээтэй</i>	288	21.9%	1,389,919.15	20.1%
<i>Муу</i>	661	50.3%	3,770,923.02	54.6%

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.1 хувь буюу 205,061,934.19 мянган төгрөгийг хэвийн зээл, 3.8 хувь буюу 8,297,650.68 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.1 хувь буюу 6,905,829.02 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 15,203,479.70 мянган төгрөгийн үлдэгдэлд 35.8 хувь буюу 5,435,542.52 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 93.1 хувийг хэвийн, 2.8 хувийг хугацаа хэтэрсэн, 4.2 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,314 зээлдэгчийн 6,905,829.02

мянган төгрөгийн үлдэгдлийн 27.8 хувийг хэвийн бус, 21.9 хувийг эргэлзээтэй, 50.3 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 пунктээр өсөж 93.1 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.2 пунктээр буурч 3.8 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.4 пунктээр буурч 3.1 хувьд хүрсэн байна.

График 7: Зээлийн чанар



Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
<b>Нийт</b>	<b>163,230,392.59</b>	<b>100.0%</b>	<b>74.1%</b>	<b>57,035,021.30</b>	<b>100.0%</b>	<b>25.9%</b>
Хэвийн	151,491,050.21	92.8%	73.9%	53,570,883.98	93.9%	26.1%
Хугацаа хэтэрсэн	5,728,348.26	3.5%	69.0%	2,569,302.43	4.5%	31.0%
Чанаргүй	6,010,994.12	3.7%	87.0%	894,834.90	1.6%	13.0%
<i>Хэвийн бус</i>	1,396,489.42	23.2%	80.0%	348,497.43	38.9%	20.0%
<i>Эргэлзээтэй</i>	1,180,217.52	19.6%	84.9%	209,701.63	23.4%	15.1%
<i>Муу</i>	3,434,287.19	57.1%	91.1%	336,635.83	37.6%	8.9%

